



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/183

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
улсын үзлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хийгдэх улсын үзлэгийг 2024 оны 11 дүгээр сарын 05-15-ны өдрүүдэд түүвэрчилсэн байдлаар зохион байгуулсугай.

2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, зарцуулагдах хөрөнгийн төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Улсын үзлэг зохион байгуулахад шаардагдах 436,150 (Дөрвөн зуун гучин зургаан мянга нэг зуун тавь) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


4.Улсын үзлэгийг чанар, үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлэхийг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т үүрэг даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 11 сарын 05 ны өдрийн 118 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
ахлагч:
Гишүүд:

Б.Болормаа
Ө.Амарзаяа

Засаг даргын орлогч
Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
хөгжлийн хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн
хамгаалал, хүүхэд, гэр бүл, залуучуудын
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
Засаг даргын Тамгын газрын Тохижилт,
худалдаа, үйлчилгээний хэлтсийн
Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл
хариуцсан ахлах мэргэжилтэн
Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн
улсын хяналтын байцаагч
Цагдаагийн хэлтсийн хэсгийн байцаагч
ахлах дэслэгч
Засаг даргын Тамгын газрын Мэдээ,
мэдээлэл хариуцсан ажилтан

Ё.Гэрэлцэцэг

М.Мөнхболд

Р.Баярсүрэн


Б.Энхжаргал

Нарийн бичиг:

С.Мягмарсүрэн

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний
хэлтсийн Хөдөлмөрийн харилцаа,
хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан
мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 11 сарын 05 ны өдрийн 1183 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



**ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Зорилго: Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиуд зарим салбарын аж ахуйн нэгж байгууллагад хэрхэн хэрэгжиж байгаатай танилцах, судалгаа хийх, зөвлөмж, чиглэл өгөх, хөдөлмөрийн маргаан, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон хуулиудын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт хийхэд оршино.

Хамрах хүрээ: Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн удирдамжийн дагуу дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын 20-30%-д түүвэрчилсэн байдлаар өмчийн хэлбэр харгалзахгүй зохион байгуулна. Үүнд дараах аж ахуй нэгж байгууллага хамрагдана.

1. "Илч-Орд" ОНӨААТҮГ
2. Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж" ОНӨААТҮГ
3. Багахангай тохижилт ОНӨААТҮГ
4. Хангай сургууль
5. Багахангай дүүргийн 44 дүгээр цэцэрлэг
6. Эрүүл мэндийн төв
7. Ян сарьдаг оргил ХХК
8. Агар эрдэс шохой ХХК
9. Алтан оршихуй ХХК
10. Мера ХХК
11. ЖДҮДТ-д үйл ажиллагаа явуулж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгч

Хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдалтай танилцах ажлын чиглэл:

1. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, мэдээлэл арга зүйгээр хангах
2. Аж ахуйн нэгж байгууллагад хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх ажилтай танилцах
3. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хавсралт хүснэгтийн дагуу дүгнэх

Хугацаа: 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл


Улсын үзлэг, хяналт хийх аргачлал:

Улсын үзлэгийг ажлын хэсгийн гишүүд аж ахуй нэгж, байгууллага дээр биечлэн очиж танилцах, зөвлөн туслах хэлбэрээр зохион байгуулна. Үзлэг зохион байгуулах удирдамжийн дагуу хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангасан талаар шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжилт тус бүр дээр тийм гэсэн хариултад 1 оноо, үгүй гэсэн хариултад 0 оноо тавьж үнэлнэ.

Шагнал урамшуулал: Хуулийн хэрэгжилтийг хангасан байдалд үнэлгээ өгч хамгийн өндөр оноо авсан 2 аж ахуй нэгж байгууллагыг шагнаж урамшуулна.

- I байр Өргөмжлөл, Мөнгөн шагнал
- II байр Өргөмжлөл, Мөнгөн шагнал

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны сарын ны өдрийн дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



УЛСЫН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Материалын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Өргөмжлөл	2	ш	50,000	100,000
Мөнгөн шагнал					
2	I байр	1	ш	200,000	200,000
3	II байр	1	ш	100,000	100,000
4	Шатахуун	15	л	2410	36,150
Нийт үнэ:					436,150